

**БНЭУ-ын Ахмедабад хотод зохиогдсон олон улсын 10 дахь удаагийн
“Сансар ба агаар мандлын шинжлэх ухаан (Space and Atmospheric science)”
сургалтанд хамрагдсан тайлан**

Улаанбаатар хот

2017.05.22

Нислэгийн цаг уурын төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн ахлах синоптик инженер Ц.Бадамханд, Буянт-Ухаа нислэгийн цаг уурын өртөөний инженер Ш.Балжинням нар БНЭУ-ын Ахмедабад хотод 2016 оны 08 дугаар сарын 01-нээс 2017 оны 04 дүгээр сарын 30 хүртэл 9 сарын хугацаатай Ази номхон далайн сансар судлал, технологийн боловсролын төвийн хөтөлбөрийн дагуу (Centre for Space Science and Technology Education in Asia and the Pacific) Физикийн судалгааны хүрээлэнгээс (PRL) зохион байгуулдаг 10 дахь удаагийн “Сансар болон агаар мандлын шинжлэх ухаан” сэдэвт олон улсын сургалтанд хамрагдсан.

Энэхүү сургалтын зорилго нь сансар болон агаар мандал судлалын талаарх үндсэн ойлголтуудыг суралцагсаддаа өгөх зорилготой дипломын боловсролын дараах сургалт юм.

Тус сургалтанд Монгол, Энэтхэг 2 улсын 12 оролцогчид суралцаж төгссөн. Энэхүү сургалт нь 9 сарын хугацаанд 2 семестерээр сургалтаа явуулсан ба эхний семестерт агаар мандал, ионосфер, газар дээр суурилсан техник, сансрын аппарат ба сансар огторгуй судлал сэдэвт нийт 203 цагийн лекц, 6 дадлагын ажил, хоёрдугаар семестерт дэлхийн соронзон орон, нар ба одон орон судлал сэдэвт нийт 120 цагийн лекц, 6 дадлагын ажил хийсэн. Энэ хугацаанд 2 удаагийн танилцах дадлагын аялал хийж энэтхэг улсын 6 хотоор аялсан ба эдгээр хотуудад орших 8 байгууллага, 1 их сургууль, түүх соёлын дурсгалт газруудыг үзэж сонирхсон.

Төгсөлтийн ажлаараа Ц.Бадамханд нь Ахмедабад хот дахь Озоны давхарга ба түүний шинж чанар, цаг тутмын болон өдөр тутмын өөрчлөлтийн онцлог (Ozone and its precursors in Ahmedabad: Features of diurnal and day-by-day variations), Ш.Балжинням нь Улаанбаатар хот дахь агаар ба хөрсний температурын өөрчлөлт (Temperature and soil moisture change over Ulaanbaatar, Mongolia) сэдвээр тус тус судалгааны ажил бичиж амжилттай хамгаалаад ирлээ.



एशिया एवं प्रशांत अंतरिक्ष विज्ञान एवं प्रौद्योगिकी शिक्षा केंद्र
(संयुक्त राष्ट्र से मान्यता प्राप्त)
Centre for Space Science & Technology Education in Asia and the Pacific
(AFFILIATED TO THE UNITED NATIONS)
समापन समारोह
Valedictory Function
अंतरिक्ष प्रौद्योगिकी विज्ञान एवं वैश्विक जलवायु - 10
SATELLITE METEOROLOGY & GLOBAL CLIMATE - 10
एवं &
अंतरिक्ष एवं वायुमंडलीय विज्ञान - 10
SPACE AND ATMOSPHERIC SCIENCE - 10
अप्रैल 24, April 2017
अंतरिक्ष अनुप्रयोग केंद्र, भोपाल कैंपस, अहमदाबाद
Space Applications Centre, Bopal Campus, Ahmedabad

